



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 11 сарын 14 өдөр

Дугаар 1122

Баянтал сум

Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийг
шинэчлэн байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 43.2, Залуучуудын хөгжлийг дэмжих тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.1, 21.1.2, Засгийн газрын 2018 оны 04 дүгээр тогтоолоор батлагдсан "Залуучуудын хөгжлийн үндэсний зөвлөлийн дүрэм"-ийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Залуучуудын хөгжлийг дэмжих салбар дундын үйл ажиллагааг орон нутгийн түвшинд уялдуулан зохицуулах, нэгдсэн удирдлагаар хангах чиг үүрэг бүхий орон тооны бус зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

ТЭРГҮҮН:	Д.Мөнх-Эрдэнэ (Засаг дарга)
ДЭД ТЭРГҮҮН:	Ш.Шинэбаяр (Засаг даргын орлогч)
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	Д.Сувд-Эрдэнэ (Архив, бичиг хэргийн эрхлэгч)
ГИШҮҮД:	Б.Мөнгөнцэцэг (Мал эмнэлгийн тасгийн улсын байцаагч)
	Б.Батчимэг (Газрын даамал)
	М.Энх-Амгалан (Жижүүр)
	С.Сод-Эрдэнэ (4 дүгээр сургуулийн биеийн тамирын багш)
	Ц.Буджав (4 дүгээр цэцэрлэгийн туслах багш)
	М.Ууганбаатар (Соёлын төвийн техникч)
	Б.Мөнхжин (Эрүүл мэндийн төвийн сувилагч)
	У.Шинэболд (Залуучуудын төлөөлөл)
	Ч.Баттогтох (1 дүгээр багийн малчин)
	Б.Нямсүрэн (2 дугаар багийн малчин)

2. Залуучуудын хөгжлийг дэмжих төрийн бодлого, хууль тогтоомж, батлагдсан дүрмийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон залуучуудын оролцоог дэмжих арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг салбар зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн хагас, бүтэн жилээр

421190069

тайлагнаж ажиллахыг Зөвлөлийн нарийн бичгийн дарга /Д.Сувд-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

3. Энэхүү захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2019 оны 03 дугаар сарын 12-ны өдрийн А/13 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Д.МӨНХ-ЭРДЭНЭ